



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 8
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9 - 35

- 1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/* 9 - 35

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 10 дугаар сарын 20-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 31 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Хүрэлбаатар;

Чөлөөтэй: С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Санчир, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Энхманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын шинжээч Ч.Батцэцэг, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Ш.Раднаасэд, Ц.Анандбазар нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: 1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж,

чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

23.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

26.“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

27.“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

28.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13
84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 21 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 82.3 хувийн ирцтэйгээр 11 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 31 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өглөөний мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг Та бүхэнд танилцуулъя.

Хуралдаанд Болдын Жавхлан сайд, Г.Амартүвшин гишүүн, Д.Тогтохсүрэн гишүүн, Ж.Батсуурь гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Ц.Даваасүрэн сайд, Х.Баделхан гишүүн, Ж.Батжаргал гишүүн, миний бие хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Нэг.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн Сангийн сайд Б.Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

19 гишүүн байхаас 10 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Ингээд 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль болон Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэж эхлэх байгаа.

2023 оны 9 сарын 29-ний өдөр Засгийн газар өргөн мэдүүлсэн байна. Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Монгол Улсын 2024 онд Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хууль, 7 Улсын Их Хурлын тогтоолын төслүүд байгаа.

Төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт нийт 21 хуулийн төсөл, 7 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн талаар дурдвал:

Нэг. Хөдөө орон нутагт ажиллах төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Хоёр. Орон нутагт орон сууц барьж ашиглалтад оруулах аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх, дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, татварын тайлагналыг хялбаршуулах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Гурав. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар ажилладаг төрийн үйлчилгээний байгууллагуудын төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтыг оновчтой болгох, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүй өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Дөрөв. Стратегийн ач холбогдолтой, урт хугацаанд хэрэгжих уул уурхайн төслүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд

нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Тав. Газрын зөвшөөрлийн асуудлыг цэгцэлж, газрын менежментийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Зургаа. Авлигатай тэмцэх байгууллагын гүйцэтгэх ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Долоо. Түншлэлийн төвийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Мөн тэргүүлэх ач холбогдолтой төсөл, хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэл хүрээнд дэмжих

зорилгоор “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Өрийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэх зорилгоор “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, стратегийн ач холбогдол бүхий эрчим хүчний төслийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай”, авто бензин, дизель түлшний үнийг тогтвортой байлгаж, нөөцийн баталгаат байдлыг хангах зорилгоор “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсрууллаа.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Б.Жавхлан сайдад баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэл, хуулийн төслүүдтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Х.Баделхан сайдаар тасалъя. Х.Баделхан сайдын микрофоныг өгье. Асуулт асууя.

Х.Баделхан: Баярлалаа. Би нэг товчхон хоёр юм асуучихмаар байна.

Нэгдүгээрт, барилгачдын хөдөлмөрийн хөлсний норм, үнэлгээ шинэчлэгдсэнээс болоод дээр үед тендер авсан, түүнээс өмнө тендер аваад ажлаа хийж байгаа хүмүүс нөгөө шинэчилсэн нормын дагуу цалин хөлс авч чадахгүй байна гэж байна.

Энэ олон жил яриад байгаа. Өнгөрсөн жил бас яригдсан.

Төсвийн тодотголоор материалын үнийн зөрүүг нь өгөөд тэгээд хөдөлмөрийн хөлсний үнийн зөрүү олгогдоогүй. Энэ асуудлыг ер нь энэ удаа шийдээд өгчих юм биш үү.

Намайг байсан үед нэг удаа хөдөлмөрийн нормын үнэлгээг тогтоогоод шийдвэр гарсан.

Дараа нь дахиад шийдвэр гарсан уу, үгүй юу гэж асуумаар байна. Нэг.

Хоёр дахь нь, прокурор, шүүхийн байгууллагын хүмүүс ер нь 2016 оноос хойш цалин хөлс нэмэгдээгүй гэж ярьдаг юм билээ.

Одоо ер нь ажлын ачаалал нь маш хүнд, хэрэг маш их байгаа. Тэгсэн мөртлөө 2016 оноос хойш цалин хөлс нэмэгдээгүй гэж ярьдаг юм байна. Энэ талаар ямар эрхийн акт гарсан. Энэ удаагийн төсөвт ямар арга хэмжээг авч байгаа юм бол? Ийм хоёр асуулт байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Х.Баделхан гишүүний асуулттай холбогдуулж Засгийн газраас хариулт өгье.

Ц.Даваасүрэн сайд асуултад хариулъя.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өдрийн амгаланг эрье.

Тэгэхээр барилгачдын ажлын хөлсийг төсөвт тусгаагүй байна гээд эсэргүүцээд байгаа улсуудтай холбогдолтой асуултыг Х.Баделхан гишүүн асууж байна.

Тэгэхээр эдний тавиад байгаа шаардлагад үндэслэл байгаад байгаа юм. Одоогийн энэ нөхдүүдийн хэлээд байгаа 2021 оноос өмнө хийгдчихсэн байгаа ажлууд дээр 2009 оны тарифаар ажилчдын цалин хөлс нь тооцогдчихсон байгаа юм билээ.

Тэгээд 2019 онд энэ ажлын хөлсний шийдвэр гарсан. Гэтэл энэ ажлууд чинь 2019-2020 оны хооронд хийгдсэн ажил байж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ ажлууд дээр авна гэдэг зүйл яриад байгаа учраас бас үндэслэл байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ төсөв хэлэлцүүлгийн явцад бас анхаарахгүй бол тарифын үнэлгээ нь 2009 оныхоор л байна гэсэн үг. Ажиллах хүчний.

Тэгэхээр 2021 оноос өмнө эхэлчихсэн одоо явагдаж байгаа ажлууд дээр бид ингэж тооцож авъя.

Тэгэхдээ тэр ажлууд нь. Яах вэ, ингэж ялгаж болох юм шиг байна лээ. Одоо яг өмнө эхэлчихсэн байгаа ч гэлээ гэсэн нөгөө 2021 оноос хойш хийгдэж байгаа бас ажлууд байгаа шүү дээ. Тэд нарын. Тийм ээ. Он дамжаад хийгдсэн. Адаглаад түүн дээр нь тооцож өгөх асуудлыг ярихгүй бол болохгүй болчихоод байгаа юм билээ.

Яах вэ, 2019 оноос өмнөхдөө бол үгүй. Тийм үү. 2019 оноос хойш тавигдсан ажлууд дээрээ бол бид 2019 оны өсгөсөн тарифаар авна гээд тэгээд байгаа юм билээ.

Тэгэхээрээ бас ч тэр нь үндэслэл байгаад байгаа юм. Яагаад гэвэл 2019 онд ажиллах хүчний тарифыг өөрчилсөн. Гэтэл энэ нь тооцогдоогүй байгаад байгаа. 2009 оныхоо тарифаар байгаа л гэж ингэж ойлгож болно.

Г.Тэмүүлэн: Нэмж Б.Жавхлан сайд хариулт өгье. Б.Жавхлан сайдын микрофоныг.

Б.Жавхлан: Тийм. Х.Баделхан гишүүн ээ, энэ тэгэхдээ хоёр талтай шүү.

Одоо хийгдэж байгаа энэ магадлан, энэ КОВИД-ын үеийн үнийн өсөлтүүдийг тооцож байгаа зүйл маань бараа, материалын үнэ дээр л хийгдэж байгаа шүү дээ. Барилгын бараа, материалын үнэ дээр.

Нөгөө талаар тендер авч гүйцэтгэл хийгдэж байгаа аж ахуйн нэгж, компаниуд бас тодорхой хэмжээний өөрсдөө эрсдэлээ тооцсон л байх учиртай.

Бүгдийг нь төсөв рүү аваачиж жихээд, энэ татвар төлөгчдийн мөнгөөр төлүүлээд, эрсдэлээ нөхүүлнэ гэж бас байж болохгүй. Тодорхой хэмжээний эрсдэлээ энэ аж ахуйн нэгжүүд бас өөрсдөө үүрэх ёстой.

Улс бол ямар ч байсан бараа, барилгын материал, энэ зүйлүүдийнх нь үнийн өсөлт дээр нь ямар ч байсан чадлаараа бид төсөв дээр ачааллыг нь бас үүрэлцээд ингээд явж байгаа шүү дээ.

Одоо Ц.Даваасүрэн сайдаас бид тэр ямар ч байсан хөдөлмөрийн хөлснийх нь асуудлууд дээр бид шинэчилж тарифаа гаргая гэж ярилцаж байгаа. Өнөө маргаашгүй шийдчих байх.

Харин түүнээс хойш төсвөөр гүйцэтгэх ажил, үйлчилгээ, энэ төслүүдийн ТЭЗҮ-г хийхэд шинэ тарифаараа тооцоолол явах болохоос биш урагшаагаа нөхөж тооцож тэр алдагдлыг нөхнө гэдэг зүйл хязгаартай шүү.

Тэр шууд болно гэж хэлэх боломжгүй.

Г.Тэмүүлэн: Х.Баделхан гишүүн нэмж тодруулах уу? Прокурор, шүүхийн цалин гэсэн.

Холбогдох албан тушаалтнууд байна уу? Х.Баделхан гишүүний асуусан асуулттай холбогдуулж прокурор, шүүх, цалин гэсэн асуултыг асуусан. Сангийн яам хариулах уу? 3 номер. М.Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Х.Баделхан гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр прокурор, шүүхийн цалин 2015, 2016 онуудад нэлээн шинэчлэлийн ажлууд хийгдээд, одоо төрийн албан хаагчдын цалин хөлсний хувьд хамгийн өндөр цалин хөлс тогтоогдоод явж байсан.

Түүнээс хойш цалин хөлсийг 8 хувиар тогтмол нэмэгдүүлж байсан.

Мөн цалин нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээнүүд явж байхдаа өндөр цалинтай хэсгийг тодорхой хугацаанд

нэмж байсан. Хоёр, гурван удаа царцааж байсан.

Ирэх 2024 оны төсвийн төсөл дээр харин нийтэд нь бүх улсын төсвөөс цалин авч байгаа төрийн албан хаагчдыг бүгдийг нь 10 хувиар нэмэхээр цалингийн төсвийг нь төсөв дээр нь тооцож тусгаад оруулж ирсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Ш.Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: Энэ чинь дагасан хууль явж байгаа. Тийм ээ? Аан.

Энэ худалдан авах ажиллагааны чинь хяналт ер нь яаж яваад байна аа? Хоёр, гурван цэцэрлэг сургуулийн юмыг хэдэн жил ярьж байна. Мэдэхгүй.

Хуулийн байгууллагад шилжүүлчихсэн гээд тэгээд мөнгө нь ингээд яваад байдаг. Ажлаа хийхгүй зогсчихсон.

Би төсөв болгон дээр ярьж байна. Сүүлдээ яг ний нуугүй хэлэхэд залхаж байна.

Тэгээд дахиад зарлаад хэн нэгэн орж хийх ёстой юу. Эсхүл. Тэгээд зарласан юм байдаггүй. Тэгсэн мөртлөө төсөв дээр мөнгө нь тавигдаад л сунжраад л яваад байдаг. Тэгээд хийсэн эзэнгүй болоод ингээд жил ирэх тусам л муудаад байдаг. Нөгөө баригдсанууд нь.

Хоёр дахь юм нь, КОВИД-той холбоотойгоор маш олон ажлуудыг ер нь цуцалсан юм шиг байна. Манай аймаг дээр гэхэд.

Тэгээд зарим нь ч үнэхээр чадаагүй юм байгаа. Үнийн өсөлт, бараа материал, тээвэр, бүх зүйлийн үнийн

өсөлттэй холбоотой. Тэгээд хөл хориотой холбоотой.

Зүгээр яаман дээр дуудаад ингээд авчихсан аж ахуйн нэгжүүдийн юмыг цуцалчхаад тэгээд орхичих юм. Үнэхээр ажлаа хийж чадаагүй бол тэгээд цуцалж болно.

Дараагийнхыг нь зарлаад явах ёстой. Одоо ингээд бас л гацаагаад нөгөөдөх нь зогсонги байдалд орчих гээд байна л даа. Б.Жавхлан сайд аа.

Энэ уг нь таны асуудал биш. Энэ худалдан авах ажиллагаа чинь Шадар сайд дээр байна уу?

Энэ гацсан, түгжирсэн, хөрөнгө оруулалт нь зогссон байгаа энэ юмнуудаа нэгдсэн байдлаар нэг авч үзэхгүй бол энэ ерөөсөө болохгүй болчихсон.

Бусад аймгууд дээр хэд байгаа юм. Мэдэхгүй. Манай аймаг дээр л лав хоёр, гурван юм ингээд нэлээн удлаа.

Боловсролын агентлагийнхан байна уу? Байвал тэд нараас би бүр нэр цохож байгаад тодорхой юм асуумаар санагдаад байгаа юм.

Энэ аж ахуйн нэгжүүдээс ирж байгаа янз янзын гомдол, саналуудыг. Боловсролын яамнаас хүн байгаа юм уу? Тэрийг нь тэгвэл чуулган дээр орж асууя даа.

Г.Тэмүүлэн: Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя.
Ц.Даваасүрэн сайд.

Ц.Даваасүрэн: Тийм.
Ш.Раднаасэд гишүүний хөндөж байгаа асуудал ялангуяа тэр нэгдсэн байдлаар ер

нь үүнийг шийдэхгүй бол болохоо больчихлоо гээд байгаа нь үнэн байх аа.

Манай яаманд ганцхан Боловсролын яамнаас л 60-аад төслийнх ирчихсэн байж байгаа. Одоо энэ төсөв нь болохоо больчихсон. Үүнийг дахиж магадланд оруулъя гэж.

Тэгэхдээ энэ дээр түрүүн Б.Жавхлан сайдын хэлээд байгаа ч бас аль аль талаасаа л ер нь асуудал байгаа юм. Зарим нь яалт ч байхгүй үнэхээр үүнийн өсөлт хөөрөгдөлд орчихсон юмнууд байна. Тэр дотор далимдуулж байгаа улсууд бас байна.

Тэгэхээр үүнийг ер нь нэгдсэн журмаар нэг кампанит ажил явуулахгүй бол. Одоо ерөөсөө ингэж байна. Хийхгүй хэвтчихэж байна.

Тэгээд л мөнгө нэхээд л хэвтчихэж байна. Мөнгийг нь өгөөд байхад гүйцэтгэл нь явахгүй ажлууд ч байна. Мөнгийг нь өгчихсөн байхад нөгөө авсан мөнгөөрөө ажлаа хийхгүй улсууд ч байна.

Тэгэхээр энэ бүгдийг одоо яг шалгаж нягталж байгаа юм нь л сул болчихоод байна гэсэн үг шүү дээ. Одоо жишээлбэл гүйцэтгэлийн хяналтыг янз бүр хийгээд байх шиг байна. Зарим нь яаман дээрээ хийгээд байх шиг байна. Заримыг нь манай Барилгын хөгжлийн төв дээр өгчихсөн нэг хэсэг байна. Өгөөгүй нэг хэсэг байна. Орон нутагт өгчихсөн нэг хэсэг байна.

Ингээд энэ чинь гурван хэсэг явчхаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт нөгөө компаниуд чинь бүр тэгээд гүйцэтгэл, хяналт нь сулраад ирэнгүүт мөнгөө авчхаад хийдэггүй. Тэгээд бас

зарим нэг нь далимдуулаад нэмэлт төсөв нэхээд хэвтчихдэг болсон.

Сангийн сайдын хэлээд байгаа үнэн л дээ. Үгүй энэ чинь тендерт орохдоо ер нь бүх эрсдэлээ бас тооцсон байх ёстой гэдэг дээр би санал нэг байгаа юм. Давагдашгүй хүчин зүйл, КОВИД-той холбогдолтой юм бол арга байхгүй. Арга байхгүй.

Тэгэхээр энэ бас далимдуулаад байгаа, зогсоогоод байгаа энэ юмнуудыг хэдүүлээ нэг.

Аудит руу өгөөд үнэндээ Б.Жавхлан сайд аа, нэг их тийм олигтой үр дүн гарч байгаа юм үнэндээ алга.

Аудит руу өгөөд шударга тэрийг хийж байгаа юм үнэндээ алга. Зүгээр л тэнд ахиад нэг хүнд суртал, ахиад бараг одоо нэг ёсондоо шан харамжийн тухай л дахин нэг шат дамжлага нэмж өгчихсөн байж болзошгүй шүү. Би тэгж бодож байна.

Яагаад гэвэл тийшээ явсан юм яг л хэвээрээ ирж байгаа байхгүй юу.

Гэтэл зарим нэг төслийг нягтлаад үзэхэд бас л үндэслэлгүй нэмчихсэн. Тэгээд ажлаа явуулахгүй хэвтчихсэн юмнууд харагдаад байгаа юм.

Тэгэхээр энэ их төвөгтэй асуудал.

Гадаадад үүнийг яаж шийддэг вэ гэхээр манайх шиг ингэж тийм хатуу төсөв баталж өгдөггүй юм байна. Төсвийг ерөөсөө тендерээр тогтоодог юм байна. Зүгээр зураг хийгээд өгчихдөг л гэсэн үг шүү дээ.

Зураг хийгээд л өгчихдөг. Тэгээд хяналтын төсөв гаргачихдаг. Нэг ийм

орчин байна гээд хяналтын л төсөв гарна. Түүнээс биш. Одоо чинь бол магадлан хийлээ, экспедицээр ороод бүгдийг нь баталгаажуулаад өгчхөж байгаа шүү дээ.

Тэгдэггүй юм байна. Тэгээд үнийг тогтоохдоо тендерээр тогтоож төсөвтөө тусгаж явдаг юм байна л даа.

Тэгээд их тийм манай практик, энэ гадаад улс орнуудын практик хоёр их зөрүүтэй.

Тэгэхдээ манай дээр энэ доголдол гараад байгаа юм. Одоо. Бүгд ингээд үнийн зөрүү гарчхаад тэгээд нөгөө ажил нь явахгүй болчихсон. Ш.Раднаасэд гишүүн хэллээ.

Тэгэхээр үүнийг нэгдсэн журмаар нэг авч үзэхгүй бол болохгүй болчихсон гэдэгтэй би үнэхээр санал нэг байна.

Г.Тэмүүлэн: Б.Жавхлан сайд нэмж хариулт өгье. Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурал дээр төсвийг нь батлаад өгчихөөр төслийн гүйцэтгэл дээр төсөл захиалагч эцсийн хяналтыг тавьж гүйцэтгүүлэх ёстой.

Та хэрвээ сургууль, цэцэрлэг ярьж байгаа бол төсвийн ерөнхийлөн захирагч нь Боловсролын яам. Хэрвээ шилжүүлчихсэн бол аймаг, орон нутаг үүнийгээ хяналт тавьж ажиллах ёстой.

Дээрээс нь зураг төсвийг нь хийсэн энэ зургийн авторууд нь хяналтаа тавих ёстой.

Ингээд шат дараатай хяналтууд нь тавиад тавиад гүйцэтгэл явахгүй болбол гэрээлэгч, захиалагч нь энэ нөхдүүд энэ ажлыг хийж чадахгүй байна, ерөөсөө бүтэхгүй нөхдүүд байна. Үүнийг хар жагсаалтад оруулж өгнө үү гээд ингээд Сангийн яам руу ирүүлдэг. Ийм л хяналттай л даа.

Тавиад өгчихсөн, батлаад өгчихсөн төсвийг төсвийн ерөнхийлөн захирагч нь хэрвээ хийж чадахгүй бол төсвийн ерөнхийлөн захирагч дээр нь арга хэмжээ авч болно. Хяналтаа тавьж чадаагүй бол. Ийм л шат дараатай явах юм. Маш ойлгомжтой тодорхой.

Та яг ямар тодорхой төсөл ярьж байгааг би яг хэлж мэдэхгүй байна. Та надад мэдээллүүдээ өгөөрэй.

Бид нар яг төслийн гүйцэтгэл дээр нь хяналт тавиад хэн нь хариуцлага хүлээх ёстой юм. Тэрийг нь нэг хараадахъя.

Г.Тэмүүлэн: Ш.Раднаасэд гишүүн тодруулъя.

Ш.Раднаасэд: Энэ 2 сум дээр байгаа юм л даа. Б.Жавхлан сайд аа.

Наадхыг чинь би мэдэхийн дээдээр мэдээд байгаа юм. Ажлаа хийж чадахгүй байна гээд цуцалсан байна. Зөв. Цуцалсан бол зөв.

Цуцлаад 3 жил боллоо. Одоо Халиун сумын цэцэрлэг, Алтай сумын дотуур байр хоёр байна уу.

Г.Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны дарга болоод тэр Архангайн нэг юм нь шийдэгдчихээгүй бол тэр нь бас яг нэг компани аваад ингээд л байж байгаа.

Урагшаа ч явдаггүй, тэгээд шинээр хар жагсаалтад оруулаад бид ингэж байгаа гэж байгаа юм.

Шинээр тендер зарлаад юм явах юм болов уу гэхээр явдаггүй. Тэгээд л тэндээ гацаад байгаад байдаг. Тэгсэн мөртлөө мөнгөн төсөв дээр ингээд л яваад хадгалагдаад. Энэ нь ерөөсөө нэг үл ойлгогдох юм байгаад байгаа байхгүй юу.

Хэн нь хаана зарласан байна, хэн нь хяналт тавих юм, захиалагч нь хэн юм гэдгийг чинь мэдээд байгаа юм. Энэ Боловсролын яаман дээр байгаа юм. Тэр нь.

Г.Тэмүүлэн: Ийм л зүйл асуугаад байгаа юм.

Ш.Раднаасэд гишүүн ер нь жил болгоны төсөв орж ирэхэд л ярьж байгаа юм. 2018 онд тавигдаж байсан юм.

Тэгээд миний мэдэхийн Ш.Раднаасэд гишүүний Говь-Алтай аймгийн Халиун болоод Алтай сумын эмнэлэг, цэцэрлэг, Архангай аймаг дээр Хангай сумын цэцэрлэг байгаа юм.

Тэгээд гурвууланг нь нэг компани авсан. Булган аймгийн Баянмогод гэдэг компани авсан. Ингээд 2018 онд тавигдсан төсөв нэг ч бүтээн байгуулалтын ажил хийгдэхгүйгээр 90, 95 хувийн гүйцэтгэл, мөнгийг нь авчихсан байгаа юм. Гүйцэтгэл мөнгийг нь авчихсан.

Тэгээд 2018 оноос хойш шүүх рүү тэр холбогдох яам нь гээд байгаа энэ Боловсролын яам, Эрүүл мэндийн яам нь шүүх рүү шилжүүлсэн. Хар жагсаалтад оруулсан гээд байдаг. Тэгээд яах вэ гэдэг асуудал болчихоод байгаа юм.

Гэтэл цаана нь тэрийг хүлээж байгаа тэр сумынх нь иргэд, хүүхдүүд тэр сургууль, эмнэлгээ хүлээгээд, цэцэрлэгээ хүлээгээд байгаа байхгүй юу.

Мөнгө нь 2018 оны төсөв дээр тавигдчихсан. Тэгээд гүйцэтгэгч компани нь авчихсан. Нөгөөдөх нь 95 хувийнхаа гүйцэтгэлийг аваад тэнд нэг ч шав тавиагүй асуудал болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр ерөөсөө яг цэвэр цүнхний бөгөөд, ерөөсөө бүр төсвийн мөнгөөр ингээд 5, 6 тэрбум төгрөг ч байна уу шамшигдуулаад алга болчихсон компанийн асуудлыг яриад байгаа байхгүй юу.

Тэгэхээр хууль руу шилжчихсэн. Тэгээд цаашаага тэр хууль шилжиж байх явцад дахиад магадгүй энэ чинь Боловсролын яам нь дахиж юу гэдэг юм тэр 3 сумын асуудлыг л хийх ёстой асуудал.

Би тэгэхээр 3 сумаар хязгаарлагдахгүй гэж хараад байгаа юм. Яг ийм хулхины, ингээд төсөв дээр тавигдсан төсвийн хуулийн ажил хэрэгжихгүй яваад байгаа асуудал байгаа. Энэ дээр хариулт өгөөч л гэдэг асуудал байгаа юм. Олон байгаа.

Тэгэхээр үүнийг нэгтгэж гаргаж ир. Тэгээд хууль хэрэгжүүлэх асуудлыг яриад байгаа байхгүй юу. Тэгээд тэнд цаана нь иргэд хүлээгээд байдаг. 2018 оны төсөвт тавигдсан гээд байдаг. Одоо 5, 6 жил болчихож байгаа асуудал байхгүй юу.

Тэгэхээр та хэд үүнийг судлаад чуулган дээр нэг хариу өгөөрэй.
Ш.Раднаасэд гишүүнд.

Ц.Анандбазар гишүүн асуулт асууя.

Ц.Анандбазар: Бид чинь 4 жилийн туршид л нэг ижилхэн төрлийн улс оронд нэмэр болохоор биш, үр дүн муутай төсөв батлаад л дуусаж байна даа.

Ер нь улсын хөрөнгө оруулалт гэхээр ийм үр дүн муутай байдаг юм уу. Бид буруу төлөвлөдөг юм уу. Дүгнэлт хийхгүй бол ерөөсөө болохгүй байна.

Уг нь Эдийн засгийн яамыг хөрөнгө оруулалтыг арай нэг бодитой болгоод, ажлын байр бий болгодог, амьдрал дээшлүүлдэг, улс эх оронд эн тэргүүний хэрэгцээтэй төсөв оруулж ирдэг яам болно л гэж бодож байгуулсан шүү дээ.

Тэгээд энэ жилийн төсвийг бүхэлдээ харахад одоо ямар ч ажлын байр гаргахгүй, амьдралыг өөд нь татахгүй ийм л төсөв болчихлоо.

Тэгээд Монгол бол одоо мөнгөтэйгийн зовлон болоод байна. Төсөв хэчнээн орлого нэмэгдээд амьдрал дээшлүүлэх хөшүүрэгтэй нэг ч ажил хийж чадахгүй байна. Тэгээд бид ч гэсэн их бодохгүй болохгүй байна.

Тэгээд нэгэнтээ төсөв түрүүчийн гишүүдийн ярьж байгаа шиг хөрөнгө оруулалтын орлого олдог, зогсоож гацааж байгаад мөнгөө нэмээд авчихдаг ийм хэрэгсэл болоод байгаа юм бол үндсэндээ аргачлал, эхлэлээ өөрчилмөөр байна.

Соёлын хувьсгал болж байгаа юм шиг л юм болж байна шүү дээ. Одоо жишээ нь энэ жил гэхэд 154 тэрбум

төгрөгийн сумын соёлын төв барихаар орж ирж байна шүү дээ.

Тэгээд энэ чинь 1945 оноос хойш соёлын хувьсгал хийж байгаа юм шиг л юм болж байна.

Одоо соёлын салбар гэдэг чинь уг нь нэг соёлын төв, улаан клуб гэдгээс өөрчлөгдсөн баймаар юм. Сумд ийм төрлийн барилгууд бариад Монгол Улс ажлын байр нэмэгдэхгүй ээ. Нэг ширхэг ч ажлын байр нэмэгдэхгүй.

Асар их мөнгийг маш их үргүй зарж байна. Хэрвээ хувийн компани ийм хөрөнгө оруулалтыг нэгийг ч хийхгүй шүү дээ. Тэгээд үндсэндээ Их Хурлын хөрөнгө оруулалтын бодлогын дампуурал гэж хэлж болохоор ийм юм болчхоод байна.

5 ажлын байр нэмчхэж болохоор, тууштай ажиллаж болохоор огт тийм төсөл хөрөнгө оруулалт алга байна.

Тийм учраас хэрвээ нэгэнтээ ингэж чадахгүй байгаа бол одоо төрийн албан хаагчдын хяналт тавьдаг хуулийн салбарын ялангуяа цалин хөлсийг нэмээд хариуцлагыг нь өндөржүүлэх асуудал онцгой чухал байна.

Энэ чинь өндөг анхдагч уу, тахиа анхдагч уу гэж ярьдаг шүү дээ. Одоо яаж байна гэхээр гүйцэтгэл хийсэн компани ажлаа хийхгүй зогсчихдог. Тэрийг хураалаа гээд, шүүхэд очлоо гээд тэр шийдэгдэхгүй үлдэж байгаа.

Энэ чинь бүтэн хуйвалдааны шинж чанартай юм болоод байна шүү дээ.

Тэрийг хариуцлага эрдэг хүн ч алга. Тэр дотроос хувь хүртэж, өөрийн

амьдралаа зохицуулдаг ийм албан тушаалтнуудын тоо л өдрөөс өдөрт нэмэгдэж байна.

Тэгээд энэ чинь инфляцад нөлөөлж байгаа хамгийн том асуудлын нэг юм болчхоод байна шүү дээ.

Тэгэхээр бид одоо энэ зорилтот төсөл дээр нэг суманд тавих хөрөнгө оруулалтын төслийг 30 хувь нь ажлын байр нэмэгдэнэ ч гэдэг юм уу, ийм тодорхой зорилтот зах зээлд зарцуулдаг болохгүй бол болохгүй нь ээ.

Ц.Даваасүрэн гишүүний тэр бяслагийн үйлдвэр гээд би Хөвсгөл дээр харж байсан.

Ядаж сум дээр бодитой орлого оруулахаар ийм ажлын байр гаргадаг төслүүдийг хэрэгжүүлээд, хэрэгжүүлсэн төсөл нь дараа нь ажилладаг байх ёстой юм.

Одоо энэ төрийн мөнгийг нэг их гайхаж байгаа юм бол хийсэн юм нь ард нь тэгээд эзэнгүй болоод орхидог. Боловсон хүчинч хөдөө их муу байна. Түүний төлөө сэтгэл тавьдаг хүн ч гэж алга.

Тэгээд бид одоо мөнгөтэй хүн ядуу амьдардгийн гайхамшигтай жишээг харуулаад байна.

Тийм учраас түрүүн Х.Баделхан гишүүний санал тавьж байсан прокурор, шүүхийн цалингийн тодорхой хувиар нэмэх саналыг дэмжиж байна. Энэ дээр тодорхой санал авмаар байна.

Ер нь тэгээд цалинг тодорхой түвшинд хүргээд, эргээд хариуцлага нэхдэг байхгүй бол төрийн албан хаагчид чинь бага цалинтай.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Б.Жавхлан сайд тайлбар өгье.

Б.Жавхлан: Санал юм уу, юу юм. Мэдэхгүй. Сайн ойлгосонгүй ээ.

Ц.Анандбазар гишүүн маань хаагуур явж байгаад өнөөдөр гэнэт хаанаас гарч ирээд. Төсвөө танилцаж амжсан юм уу, амжаагүй юм уу мэдэхгүй.

Ерөнхий сайдын ажлын баг сая 8 сард 16 аймаг, өмнө нь 5 аймгаар явсан юм. Булган аймаг дээр ажиллаж байхад гишүүн өөрөө байсан байх аа.

Тэр үед ярьж байсан зүйл, одоо ярьж байсан зүйлээ ер нь 180 градус эргэчихсэн хаана ямар буруу юм уншчихсан юм.

Орон нутагт баригдаж байгаа соёлын байгууллагуудын бүтээн байгуулалтыг та ад үзээд хэрэггүй ээ.

Та чинь өөрөө соёлын салбарын хүн гэж би дуулсан шүү дээ. Шүлэг бичдэг гэлүү, шүлэг уншдаг гэлүү.

Энэ зүгээр зохиогоод тавьчихсан асуудал биш шүү.

Энэ орон нутгийн ард иргэдийн санал асуулгаар яг танай аймагт, таны өөрөө биечилж оролцсон яг тэр хэлбэрээр бүх аймгууд дээр яваад, тэндээс эрэмбэлэгдэж гарч ирсэн ийм бүтээн байгуулалтын ажлууд. Тэрийг ад үзээд хэрэггүй.

Төсвийн нэг төгрөг болгон баялаг бүтээж, эдийн засгийн хөгжлийг дэмжиж явах учиртай. Урсгал зардал нь ч тэр, бүтээн байгуулалт нь ч тэр, хөрөнгө оруулалтууд нь ч тэр.

Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд ирэх жил ингээд салбар салбараар нь харах юм бол эрчим хүчний салбар дээр ирэх жил 1.1 их наяд буюу хамгийн том хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийгдэх ажлууд байгаа.

Дараа нь, зам тээвэр 750.0 тэрбум төгрөг.

Мөн барилга, хот байгуулалтын салбар 700-аад тэрбум төгрөг гээд.

Хувийн хэвшил, баялаг бүтээгч нарын ажлаа хийх, үйлдвэрлэлээ явуулах, аж үйлдвэрээ сэргээх энэ бүх боломжуудыг нь бүр илүү болгохын тулд ийм сэргэлтийн бодлогуудыг чухалчилж, яг хөгжлийн эдийн засгийг дэмжсэн ийм хөгжлийн хөрөнгө оруулалтуудын ийм жил ирэх жил үргэлжлэх болно.

Өмнөх жилүүдийн ийм чиглэл барьсны үр дүнд эдийн засгийн хөгжил дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ирэх жил ийм үр дүн авчирч байгаа.

Тийм учраас энэ олон хийж гүйцэтгэж байгаа үр дүн гарч байгаа ажлыг ямар сэдлээрээ мэдэхгүй ингэж үгүйсгэж арай болохгүй байх. Нүдэнд харагдах, гарт баригдах үр дүн гараад явж байгаа юм. Энэ жил ч гарна, ирэх жил ч гарна. Тийм.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр гишүүд анхаараарай.

Би энэ дагасан хуулиудтай холбогдуулан 21 хууль, 7 тогтоол байгаа. Үүнтэй холбогдуулж нэг зүйлийг тодруулж асууя.

Бусад асуудлуудыг холбогдох сайд нар нь чуулганы танхимд байгаа учраас чуулган дээр асууя.

Газрын тухай хууль. Газрын тухай хуультай холбоотойгоор нэг анхаарах зүйл байна.

Энд гол анхаарах гээд байгаа зүйл нь энэ 18.1.10-тай холбоотойгоор одоо мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчинтойгоо зөрчилтэй нэг ийм заалт орж ирсэн байна гэж хараад байгаа юм.

Тэгэхээр юу байх вэ гэхээр энэ иргэн болоод аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох шийдвэр гаргах эрхийг нь одоо бол одоогийнхоо хуулиар орон нутаг, орон нутгийн удирдлагууд гаргаж байгаа.

Гэтэл үүнийг Засгийн газарт шилжүүлж, Засгийн газар магадгүй тэр суманд, дүүрэгт газар олгох асуудлыг шийдэх энэ эрхийг дангаар эзэмших гэдэг юм уу, зохицуулалтыг хийж байгаа шинэ зохицуулалтын харилцаа орж ирээд байгаа юм.

Тэгэхээр ер нь би зүгээр Газрын тухай хуульд энэ нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хуулийн төслийн маань энэ үзэл баримтлал ер нь яг юу юм бэ?

Та бүхэн товчхон танилцуулаад байгаач. Яг ямар үндэслэлийн хүрээнд үүнийг зөвхөн Засгийн газар луу татаж, орон нутгийн эрх мэдэлтэй холбоотой энэ асуудлыг ингэж хязгаарлаж байгаа зохицуулалт хийгдсэн юм бол? Энэ дээр нэг тайлбар өгөөч гэж хэлэх гээд байгаа юм.

Түрүүний тендерийн хууль дагалдах хууль болж орж ирсэнтэй

холбогдуулж Ш.Раднаасэд гишүүн болоод миний хэлээд байгаа зүйл бол хариуцлагын санкцыг нь яагаад ч оруулж ирээгүй юм бэ? Яг ингээд цүнх үүрсэн, гүйцэтгэл хийдэггүй, төсөв мөнгийг нь авчихсан компаниуд чинь хариуцлагагүй явчихдаг.

Тэгэхээр магадгүй шүүх нь шүүхээр яваг. Бусад цагт тэр төсөвт тусгагдсан хууль хэрэгжих ажлыг нь хариуцлагажуулах тэр санкцыг эрх зүйн орчны өөрчлөлтийн хүрээнд хийж өгөөч ээ л гэдэг санал байгаа юм.

Үүнийг анхаарч үзээрэй.

Саяын газартай холбоотой, Газрын тухай хуультай холбоотой үзэл баримтлалын хүрээнд тайлбар хэлэх үү. Засгийн газраас 3 номер. Албан тушаалаа танилцуулаад, нэрээ хэлээд.

Ч.Дондогмаа: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслөөр Газар зохион байгуулалт, геодези, зориг зүйн агентлагийг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулаад, Засгийн газрын бүрэн эрхийг өргөжүүлж тодорхойлсон байгаа.

Энэ нь 7 дугаар сард Улаанбаатар хотод болсон гамшиг, үер, ослын асуудалтай холбогдуулаад Засгийн газраас тогтоол гарсан.

Энэ тогтоолоор Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу энэ агентлагийг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллуулж, газрыг энэ агентлаг улсын болон хэсэгчилсэн

ерөнхий төлөвлөлтөд нийцүүлж газар олгох дүгнэлтийг гаргадаг.

Энэ агентлагаас зөвшөөрөл дүгнэлтэд нийцсэн гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд Засгийн газар эрх олгоод газар олгох шийдвэрийг Засаг дарга гаргах ийм зохицуулалтыг Засгийн газрын бүрэн эрх дээр нэмж тусгасан байгаа.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энд нэг ойлгомжгүй зүйл. Сая тэр 18.1.10 чинь яг өргөн баригдсан зохицуулалтаараа таны ярьж байгаа агуулгатай бас яг нийцэж байна уу, үгүй юу? Яг энэ өргөн баригдсанаараа та хэд хуулийнхаа төслийг явуулна гэсэн үг үү?

Эсвэл энэ дээр бид бас анхаарч үзэх ёстой гэсэн үг үү? Яг таны тайлбарлаж байгаатай холбогдуулж найруулж бичсэн зүйл зөрчилтэй асуудал байгаа юм 7 номер хариулах уу, 3 номер уу? 7.

Ц.Баярбат: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат. Г.Тэмүүлэн даргын асуултад хариулья.

Үүнийг ажлын хэсэг дээрээ дахиж анхаарч үзэх ийм томьёоллууд байгаа гэж ингэж үзэж байгаа. Ажлын хэсгээс.

Ер нь түрүүнд Ч.Дондогмаа даргын хэлснээр энэ бол үндсэндээ хоёр л үндэслэлтэй юм.

Нэгдүгээрт, аймаг, нийслэл, сумын Засаг дарга, нийслэл, дүүргийн Засаг дарга нарын газар олголттой холбоотой гаргаж байгаа энэ шийдвэрүүд маань өөрөө яг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдэхгүй байна.

Тэгэхээр үүнийг нэгдүгээрт хянаж үздэг. Тэгээд холбогдох зөвшөөрлийг нь олгосны үндсэн дээрээс эрх бүхий этгээд нь шийдвэрээ гаргадаг байх энэ зохицуулалтыг авч үзсэн.

Хоёр дахь нь, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлж байгаатай холбогдуулан энэ хуулийн заалтыг томьёолж оруулж ирсэн.

Ажлын хэсэг дээр бид найруулгын шинж чанартай зүйлийг дахиж харах ийм санал нэгтэй байгаа.

Г.Тэмүүлэн: Б.Жавхлан сайд нэмж тодруулья.

Б.Жавхлан: Г.Тэмүүлэн дарга аа. Нэг ийм юм байгаа юм.

Бид ер нь цаашдаа төсвийн хөрөнгө оруулалтын бие даасан хуультай болох нь хэцүү юм байна лээ.

Одоо яг бид төсвийн шинэчлэл гэж их ярьдаг. Төсвийн шинэчлэл явж явж яг энэ дээр л очдог байхгүй юу. Үүний хэрэгжилт нь ямар байхаас.

Тэгэхээр төсвийн хөрөнгө оруулалт маань, төслийн ажил маань маш олон үе шаттай. Маш олон үе шаттай.

11 сарын 15-нд төсвийн хууль батлагдаад л ажил нь эхэлдэг.

Э.Алтанзул аа, би чамд юм яриад байна шүү. Чи яг ингэдэг шүү.

Би Г.Тэмүүлэн даргад хандаж ийм юм хэлж байна. Санаа хэлж байна.

Дандаа хажуугаас нь буруу, худлаа мэдээлэл өгнө, үймүүлнэ.

Тийм учраас маш олон оролцогч олон талаасаа хамаардаг ийм зүйл учраас одоо яг төсвийн хуулийн дагуу бүрэн хяналт тавьж чаддаггүй. Маш олон салбарын хуулиуд дээр зохицуулалтууд нь орчихсон, тал талаасаа яг өөр өөрсдийнхөө хуулиудыг бариад явчихдаг учраас.

Одоо сая Ш.Раднаасэд даргын ярьж байгаа, Ц.Даваасүрэн сайдын ярьж байгаа энэ зовлонгууд ер нь яг ийм зохицуулалт дутуу байгаагаас л болж байгаа юм.

Одоо бид төсвийг нь батлаад явуулдаг. Эцсийн дүндээ төсөв дээр ганц эрх мэдэл нь юу байдаг вэ гэвэл хар жагсаалтад оруулна л гэж айлгадаг. Өөр бид хяналт тавьж, зогсоож ийм зохицуулалт тавих хүч аягүй дутуу их юм байна лээ.

Тийм учраас үүнийг нэг бодмоор юм байна лээ дээ.

Ер нь яг төсвийн реформын дотор явж явж хамгийн том проблем ерөөсөө яг энэ л байгаа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо.

Тэгэхээр Засгийн газраас, Барилга, хот байгуулалтын яамнаас Төрийн нарийн бичгийн даргын хүрээнд яг энэ 18.1.10-тай холбоотой заалт дээр тодорхой анхаарч ажиллах ёстой. Томьёололын хувьд алдаатай зүйл байна гэсэн зүйлийг хэлж байна.

Тэгэхээр үүнийг Байнгын хороо болоод ажлын хэсгийн зүгээс анхаарах ёстой.

Б.Жавхлан сайд аа. Бид хэлэлцэж байгаа холбогдолтой асуудлаар асуудлыг хөндсөн.

Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны үйл ажиллагаатай хамааралтай асуудалд та шүүмж, санал хэлээд байх шаардлага байхгүй гэж харж байна.

Би хоёр дахь асуудал.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль байгаа.

Энэ дээр өчигдөр төсвийн төслийг хэлэлцэж байх үед бас нэг үзэл баримтлалтай холбоотойгоор зөрүүтэй нэг байр суурийг Уул уурхайн сайд илэрхийлсэн. Уул уурхайн яамнаас үүнтэй холбоотой холбогдох албан тушаалтан байна уу?

Тэгэхээр энэ өргөн баригдсанаараа та хэд энэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульдаа нэмэлт оруулах тухай хуулийнхаа төслийг энэ чигээр нь явуулахад байр суурь хэвээр байгаа юу? Эсвэл өчигдөр сайдын тайлбарласнаар арай өөр өнцөгтэй зүйл ярьсан.

Бараг үүнийгээ буцааж татах юм уу, эсвэл өөрчлөх асуудлыг ярина гэдэг асуудлыг ярьсан.

Энэ дээр нэг тайлбар өгөөч. Хэдэн номер уу? Уул уурхайн яам байна уу?

Уул уурхайн яамнаас хүн байхгүй бол чуулганы танхим дээр энэ асуултад хариулаарай. Тайлбар өгөөрэй.

Хэрэг эрхлэх газрынхан энэ дээр анхаарч ажиллаарай.

Гишүүд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа. Саналтай гишүүд байна уу? Үг хэлэх гишүүд байна уу? Нэрсээ өгөөрэй.

Ж.Батсуурь гишүүнээр тасалъя.
Ж.Батжаргал гишүүн саналаа хэлье.

Ж.Батжаргал: Төсвийн тухай хууль дагуулж өргөн барьсан хуулийн төслүүдтэй танилцсан.

Хэд хэдэн хуулийн төсөл дээр тодорхой саналууд байгаа юм.

Тэгээд энэ саналуудыг мэдээж өргөн баригдаад ороод ирчихсэн учраас ажлын хэсэг дээр нэлээн сайн авч үзэж ярилцах ёстой болов уу гэж бодож байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль дээр нэгдүгээрт хэрэгжилтийн хугацаан дээр өөрчлөлт оруулах санал ороод ирчихсэн юм билээ.

Бид улсын төсөв батлагдаад, тэгээд бэлтгэл ажил хангагдаад ер нь 12 сарын 01-нээс мөрдөгдчихвөл дараа жилийн хөрөнгө оруулалтын ажил нь арай эрт явчих бололцоо бүрдэх юм гэж үзэж зориуд энэ 12 сарын 01 гэдэг тоог оруулсан.

Гэтэл 01 сарын 01-нээс бүрдүүлэхээр ийм санал орж ирж байгаа юм билээ.

Үүнийг ажлын хэсэг дээр нэлээн анхаараарай гэж би зориуд хэлмээр байгаа юм.

Дараагийн нэг зүйл нь, тэр стратегийн ач холбогдолтой орд газруудын ашиглалттай холбоотой асуудал байгаа юм.

Биржийн тухай хууль ч тэр, энэ хууль ч тэр, энэ хоёр хуулиар бид тухайлсан нэг асуудал дээр хариу гаргаж өгөх гэж байгаа нэртэй ийм юм оруулах юм бол өнөө жаал хумьж хариуцлага, сахилга, авлига элдэв бусын юмаа бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлууд чинь задарч цонх гаргаж өгөх болно шүү.

Тийм учраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль дээр төрийн өмчтэй компанийн ашиглалтын буюу хайгуулын талбай дотор тэр компани дахиад бусад компаниудаар хайгуул, олборлолтын ажил явуулж болохоор ийм заалт орж ирж байгаа явдал бол энэ болохгүй ээ.

Тийм учраас үүнийг засах ёстой гэж.

Биржийн тухай хууль мөн ялгаа байхгүй. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль дээр бид ер нь уул уурхайн бүтээгдэхүүн экспортын 93 хувийг эзэлж байна.

Үүнийг биржээр дамжуулж хилийн нөхцөлөөр нь борлуулъя. Ингэж байж үр өгөөж нь нэмэгдэх юм гэсэн. Нэмэгдсэн.

Үр өгөөжтэй юм байна гэдгээ харцгаасан. Тэгээд одоо буцаагаад биржийн биш худалдаа хийх, гэрээний нөхцөлөөр хийх бололцоо бүрдүүлж өгөх эрх зүйн цонх нээх гээд байгаа явдал бол их эргэлзээтэй зүйл шүү. Үүнийгээ томьёолол юмаа эргэж хараарай гэж.

Дараагийн нэг зүйл, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байгаа юм. Энэ 18.1.10 гэдэг бол угаасаа томъёолол буруу.

Хяналт тавих бололцоо байгаа.

Газрын мэдээллийн сан нэгдсэн цахим системд орчихсон. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө бүх шатдаа хийгдэж байгаа. Тэр төлөвлөгөөнийхөө утга агуулгад тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь нийцэж үү, үгүй юу гэдгийг энэ төвд ажиллаж байгаа үндсэн агентлаг хянаад сууж байх бололцоотой.

Тэр тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлууд дээр яг тэр нөхцөл, зориулалт, шаардлагаараа газар олголт нь явагдаж уу, үгүй юу гэдгийг тэнд шийдвэр гаргаж байгаа этгээдийн гаргасан шийдвэрийг хянаад сууж байх бололцоотой.

Энэ чинь угаасаа газар олгохоор солбилцлоороо мэдээллийн санд орж байгаа зүйл шүү дээ.

Тэгэхээр ийм байдлаар тайлбар хийх боломжгүй шүү нөхдүүд ээ.

Ер нь зүгээр би бол үүнийг агуулга талаас нь хараад өнөөдрийн энэ Газар өмчлөлийн тухай хуульд байж байгаа заалтын нэг адил авч үзэж байгаа юм байна даа.

Тухайн жилд иргэн, аж ахуйн нэгжид зориулалт, байршил, хэмжээгээр нь ийм газар өмчлүүлж болно гэдэг юмыг орон нутгуудаас дамжиж санал аваад, тэр нь ул Засгийн газар дээр нэгтгэгдэж нэг хавсралт болж гараад, буцаад хэрэгжихээрээ орон нутгууд хэрэгжүүлдэг энэ л аргачлалыг энэ

эзэмшил, ашиглалт хоёр дээрээ авч хэрэгжүүлэх гээд байгаа улс юм байна гэж харсан чинь буцаад өөр юм ярьцгаагаад байгаа шүү. Үүнийгээ эргэж хар гэж. Нэг.

Дараагийн нэг зүйл, Орон нутгийн эрх бүхий байгууллагуудын өөрт олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд гаргачихсан хүчин төгөлдөр шийдвэрүүдийг аль нэг агентлаг дээр хянаад бүртгэдэггүй юмнуудыг энэ хуулиудаас авч хаях ёстой.

Дан дамаа тэр геологи, уул уурхайн кадастрын алба гэж нэг алба орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлууд бүрэн эрхийнхээ хүрээнд орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгуудыг бүртгэж өгөхгүй байгаа.

Тэгээд тусгай зөвшөөрлүүд олгоод байгаа явдал бол энэ Монгол Улс төрийн бодлогын хувьд эрх зүйн нэгдмэл байдлыг алдагдуулж байгаа шүү.

Энэ мэтийг харин яг энэ хуулиудад хөндөж оруулж ирж засаж залруулж, бодлогын нэгдмэл байдал, хуулийг нэг мөр ойлгож, нэг мөр хэрэгжүүлэх үйл явцдаа ахиц гаргах ёстой гэж би хардаг.

Дараагийн хууль. Энэ Гаалийн тухай хууль байгаа юм. Гаалийн тухай хуульд орон нутагт ажиллаж байгаа албан хаагчдад.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ж.Батжаргал гишүүнд нэмж 1 минут өгье.

Ж.Батжаргал: 5 жил тутамд 12 сараар орж ирж байгаа юм. Бусад бүх төрийн албан хаагчид 6 сартай.

Тэгэхээр хууль ижил, ялгаваргүй байдлаар л үйлчлэх тийм л зарчим байгаа.

Тийм учраас орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдаа бид дэмжилгүй яах вэ. Тэгэхдээ нэг ижил зарчим барих ёстой.

Тийм учраас үүнийг тэр 6 сар гэдэг рүү нь оруулах ёстой гэж.

Дараагийн нэг асуудал байна. Энэ Ирээдүйн өв сангийн тухай хууль. Энэ Тогтворжилтын сан, Ирээдүйн өв сан хоёрыг бид нэлээн өөр байдлаар харахгүй бол болохгүй болчихоод байна.

Энэ яригдаад байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлууд энэ тэрийн үед л ашиглана гэж үзсэн өнөө сангуудаа буцаагаад урсгал зардал болгож ашиглаад яваад байгаа явдал болохгүй байна.

65 гэж байсан юмыг 20 болгохоор орж ирчхээд байгаа юм.

Тэгэхээр заавал хүүхдийн мөнгийг төсөв рүүгээ татаж халамж хэлбэрээр тарааж байх хэрэг байгаа юм уу?

Г.Тэмүүлэн: Ойлголоо.
Ш.Раднаасэд гишүүн үг хэлье.

Ш.Раднаасэд: Засгийн газрын гишүүд гараад явчихлаа.

Түрүүн тэр Худалдан авах ажиллагааны хууль дээр хэлчихлээ. Хариуцлагын юмыг нь жоохон нэмэхгүй бол одоо нөгөө хөндөөгүй заалт хөндөж болохгүй гээд ороод ирэх вий. Одоо тэгээд бас ажлын хэсэг дээр чадахгүй гэнэ.

Энэ Газрын хууль дотор чинь тэр Засгийн газраас төвлөрүүлнэ гэдэг чинь нөгөө орон нутгийн эрх мэдлийг.

Уг нь бид чинь эрх мэдлээ задалъя, эрх мэдлийн төвлөрлийг байхгүй болгоё, санхүүгийн эрх мэдлийг орон нутагт нь өгье. Тэгж байж цаашаа энэ Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрөл чинь алга болно гээд л байгаа. Тэгсэн мөртлөө яг энэ хууль болж орж ирэхээрээ ингээд өөрөөр орж ирээд байх юм.

Үүнийг угнь эргэж харж дахиж ярих ёстой байх.

Мэдээж газар олголттой холбоотой зөрчлүүд л маш их байгаа. Орон нутагт. Маш их байгаа. Тэр бол.

Тэрийг нь яаж цэгцлэх талаас нь хийх вэ гэхээр эсрэгээр нь л хараад хийчих шиг болох юм.

Би нэг зүйлийн санал хэлэх гэсэн юм.

Төсвийн байнгын хорооны гишүүдэд хандаж. Энэ ажлын хэсэг Д.Тогтохсүрэн дарга гараад явчих шиг боллоо.

Бид ингээд 52 ширхэг соёлын төв байгаа. Сумуудад. Аймаг, орон нутгаас санал авахаар өөрсдийнхөө өгсөн саналын хэмжээнд ард иргэд нь саналаа өгчхөж байгаа юм.

Соёлын төв байх уу, спорт заал байх уу гэхээр соёлын төв байх гэдэг ч юм уу. Тийм ээ. Тэгээд иргэдийн саналаар дэмжигдсэн санал гээд.

Тэнд Улаанбаатар хотын хэмжээнд улсын хэмжээнд нэг ийм юм баймаар байна гэж санал асуугаагүй

учраас тэр талаар ерөөсөө санал өгөхгүй байгаа байхгүй юу.

Тэгээд миний ярих гээд байгаа юм бол энэ Хавдрын эмнэлгийг хэдүүлээ нэг бариад өгчихье. Зөвхөн дэд бүтцийн юуных нь ажил байна лээ. Дэд бүтцийг нь татах ажил байна лээ. Наадах чинь нийтдээ 140 орчим тэрбум төгрөгөөр босчихоор юм билээ.

52 соёлын төв дээр 154 тэрбум төгрөг. Ямар ч байсан 52 соёлын төв шинээр баригдах ийм л юм явж байна лээ. Бүх сумууд дээр шахуу. Дандаа энэ орон нутагт байсан юм. Тэгээд 2024 оны сонгууль чинь пропорциональ явагдана.

Тойргоос хүн гарахаас гадна намын лам гэдэг листээр том бодлогын юм явна. Үүнийгээ бодоод аль аль намууд нь үүнийг дэмжээд үүнийг хавдрын эмнэлгийг нь бүтнээр нь тавиад өгчихмөөр санагдаад байна.

Тэр нөгөө эрхтэн шилжүүлэх юуг нь тавьчихсан юм байна лээ. Төсвийг нь 100 хувь. Тэр чинь 800 орчим хүний зовлонгийн асуудал байдаг юм. Энэ хавдрын өвчлөл чинь бүх аймаг, сум, айл, бүр баг бүрт байна шүү.

Тэгээд үүнийг би ажлын хэсэгт орж байгаа гишүүд энэ дээр нэг онцгой анхаараад үүнийг тавиадхаач ээ гэж хүсмээр байна.

Яг энэ сайд нар бүгд гараад явчихлаа.

Одоо ганц Б.Чойжилсүрэн сайд л сууж байна л даа. Зарим сайдынх нь салбарт нь тавьж байгаа төсөв тойрогт нь тавьж байгаа төсвөөс бага байгаа шүү. Салбарын асуудал биш. Тойргийнх нь

төсөв нь өөрт нь их тавигдсан байгаа байхгүй юу.

Тэгээд ингээд бодохоор үүний цаана юу харагдаж байна гэхээр нөгөө л буруу тогтолцоо. Одоо энэ зөв жишиг рүүгээ явъя гээд Үндсэн хуулиа сая өөрчиллөө. Дараа нь энэ сонгуулийн хуулиа баталлаа.

Тэгвэл энэ төсвийн жилээс төсвийн хуулийг батлаад ирэх жилээс эхлэхдээ үүнийгээ хийгээд эхэлье л гэж бодоод байгаа юм. Энэ бол аль аль талдаа хэрэгтэй байна. Энэ эмнэлгийн асуудал.

Одоо ингээд энэ хүүхдийн эмнэлгүүд яригдана.

Тэгээд бид гэртээ хөргөгчгүй, эсвэл плиткгүй байж өндөр үнэтэй зургийн аппарат авч байгаа айл шиг л харагдаж байгаа шүү дээ. Тэнд хүмүүс эмнэлэгт хэвтээд эмчлүүлэх эмнэлэггүй байхад энэ соёлын төвөөр яах юм бэ. Энэ аймаг, сумдын Тамгын газраар ер нь яах юм бэ.

Тэгээд энэ дээр ажлын хэсэгт орж байгаа гишүүд онцгой анхаараад яриад өгөөч. Би зүгээр тодорхой саналуудыг гаргаж өгье. Тэр үеэр нь бичгээр.

Ийм л санал байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ц.Сандаг-Очир гишүүн үг хэлье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Сайд нар жоохон үг дааж үг сонсох хэрэгтэй шүү дээ.

Тэгээд үг хэлсний төлөө, гишүүдийг юм хэлсний төлөө ингээд л нэг уурлаж уцаарлаад л бухимдаад байх хэрэг ерөөсөө байхгүй шүү дээ.

Энэ чинь өнгөрсөн хоёр, гурван жилийн хугацаанд гишүүд чинь хоёр жил нь КОВИД-той, Засгийн газрын оруулж ирсэн саналыг байж болох хэмжээнд нь дэмжээд л явсан.

2023 онд нэг ч шинэ хөрөнгө оруулалт байхгүй гээд л оруулж ирсэн. Дэмжээд л явсан.

Энэ бүрэн эрхийн хугацааны хамгийн сүүлийн жил шүү дээ.

Ард түмнээсээ сонгогдсон гишүүд чинь бас нэг орон нутагтаа хэлэх ярих үзүүлэх юмтай гээд ганц нэг хөрөнгө оруулалтын ажил суулгачих юмсан гээд л бодож байгаа шүү дээ.

Анх удаа л хөрөнгө оруулалт суулгах гээд л. Ирэх жилийн төсөв арай гайгүй болж байгаа гээд л ярьж байгаа шүү дээ.

Гэтэл одоо тэгээд энэ дээр нь асуудлууд нь янз бүр л байх юм.

Тэгээд би Төсвийн байнгын хорооны дарга болоод ажлын хэсгийн дарга хоёрт санал хэлж байгаа юм. Албан бичгээр өнөөдөр тоот өгье.

Нэгд, өчигдөр би асуусан. Төсөв өргөн баригдсанаас хойш магадлал хийлгэж аудитаар хянагдсан хөрөнгө оруулалтын ажлууд байгаа юм байна лээ.

Миний авсан мэдээллээр 50 гаруй хөрөнгө оруулалтын ажлууд хянагдаад явж байна гэж.

Сангийн сайд төсөв өргөн баригдахаас өмнө ирсэн, Сангийн яаманд хянагдаж ирснийг оруулсан. Өргөн баригдсанаас хойшийг оруулах бололцоо

боломж гараагүй байна. Ажлын хэсэг дээр хэрхэн яаж шийдэхийг шийднэ гэж байх шиг байсан.

Төсвийн байнгын хороон дарга, ажлын хэсгийн дарга нар аудит дээр хэчнээн хөрөнгө оруулалтын ажил байгаа юм. Үнийн дүн нь хэд байгаа юм. Нийтдээ. Үүнийг яаж ирэх жилийн төсөвт суулгах юм гэдэг энэ асуудлыг албан ёсоор ярьж өгөөрэй.

Энэ цаанаа ахиад л үргэлжилж байгаа ажлууд. Хэрвээ үнийн зөрүү нь суухгүй бол тэгээд энэ ажлууд ирэх жил ахиад л гацна гэсэн үг. Нэгд.

Үүнийг ажлын хэсэг дээр ярьж өгөөрэй гэдгийг зориуд Төсвийн байнгын хорооны гишүүний хувьд хэлж байна.

Хоёрт, Засгийн газар өнгөрсөн жил төрийн албан хаагчдын цалин, цалингийн шат шатлал, зэрэглэлийг бууруулж байгаа. Ялгааг арилгаж байгаа гэж байгаа. Бас л дутуу байна.

Нэг талаасаа ирэх жил цалин, орон нутгийн нэмэгдлүүдийг алсын гурван дүүрэгт хамруулж өгч байгаад нь баярлаж байгаа юм.

Гэхдээ дутуу байна. Онцгой байдлын албан хаагчид. Яг нөгөө гамшиг, аваар ослын үед ажилладаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албан хаагчид энэ ангилалд чинь ороогүй. Бусад төрийн захиргааны, улс төрийн, нийтлэг үйлчилгээнийхэн нь ороод явчхаж байгаа юм байна.

Ингээд тэнд чинь ажиллаж байгаа албан хаагчид бас л ялгаатай байдал, ялгавартай байдал байна гэдэг асуудал яригдаж байгаа. Г.Тэмүүлэн дарга аа.

Тэгэхээр энэ ялгааг арилгаж байгаа юм бол арилгасан шиг арилгаад, аль нэг салбарынхныг гомдоохгүйгээр үүнийг дахиж асуудал болгохгүйгээр, хэл ам гаргахгүйгээр бүгдийг нь шийдчихээч ээ.

Энэ чинь алсын гурван дүүрэг дээр орон нутгийн нэмэгдэл гээд цөөхөн л албан хаагчид байгаа шүү дээ. 400, 500-гаар хэмжих хэмжээний.

Тэгээд хагас дутуу хийчхээд. Нөгөөдүүл нь мэдээж барьцах нь ойлгомжтой шүү дээ. Бусад салбарынх нь.

Тийм учраас үүнийг ажлын хэсэг дээрээ, Төсвийн байнгын хороон дээр ярьж өгөөч ээ гэдэг ийм хоёр санал хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Зарчмын санал хэлж байна.

Гишүүд үг хэлж байхад Засгийн газрынхан, сайд нар хаана байна? Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд.

Газартай холбоотой асуудлууд яригдаж байна. Тендерийн тухай хуулиуд яригдаж байна. Шадар сайд байна уу?

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдыг ойлгож байна. Чуулган дээр асуудлаа танилцуулж байна. Гишүүд хэлж байгаа санал, зарчмын зөв зүйтэй саналуудыг хэлж байгаа шүү.

Энэ дээр дагасан хуулиудтай холбоотой, Ирээдүй өв сантай холбоотой, Тендерийн тухай хуультай холбоотой.

Б.Чойжилсүрэн сайд сайд нараа дуудаарай.

Тэгж байж цааш нь үргэлжлүүлж байя.

Ц.Даваасүрэн сайд байна уу? Холбогдох яамдын дарга нар чуулган дээр сая гишүүдийн хэлсэн саналтай холбогдуулж хариу тайлбар мэдээллүүдээ бэлдэж байгаарай.

Газартай холбоотой нэлээн асуудлыг хоёр, гурван гишүүд хөндсөн. **А.Энхманлай** манай дарга ирсэн байсан байна.

Чуулган дээр саяын тодорхой хуулийн заалттай холбоотой асуудлаар тайлбар өгөөрэй.

Ж.Батсуурь гишүүн үгээ хэлчихье.

Ж.Батсуурь: Төсвийн тухай дагасан хуулиуд орж ирж байна.

Тэгэхээр дагасан хуулиудаар орон нутгийн эрх мэдлийг л бүр татаж авсаар байгаад орон нутаг гэж ёстой шүдгүй арслан гэдэг шиг юм болчихлоо.

Нэгжийн хуулиар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний тэргүүлэгчдийг байхгүй болгочихсон.

Тэгээд мөн томилгоотой холбоотой асуудлууд хэвтээ түвшинд байсан бүх агентлагийн удирдлагуудыг салбарын хуулиудаараа татаад авчихлаа.

Одоо аливаа бүх маргаан анхан шатад шийдэгддэг. Гэр бүлийн маргааныг ч гэсэн. Гэр бүлийн маргааныг хаа нэг газар шийддэггүй шүү дээ. Тухайн газраа л шийдэгддэг.

Тэгэхээр баг дээр болж байгаа зүйл, сум дээр болж байгаа зүйл, аймаг дээр болж байгаа зүйл маш шуурхай шийдэгдэх, маш шуурхай арга хэмжээ авах боломж орон нутагтаа л байгаа.

Гэтэл одоо энэ Газрын тухай хууль дээр дагаж оруулж Засгийн газар луу татаж авна гэдэг бүр хаа газарт байгаа хилийн дээсэн дээр байгаагаас тэр маргааныг Засгийн газар татаж авна гэдэг бол хэзээ ч шийдэгдэхгүй. Эцэс төгсгөлгүй л зүйл болно гэсэн үг.

Хэдийгээр өнөөдөр цахим орчинд орчихсон, хурдан түргэн хариулдаг гэдэг боловч.

Өнөөдөр сая Ш.Раднаасэд дарга хэлээд байна шүү дээ. Яаман дээр байгаа цуцалчихсан юмыг ахиад шийдвэрлэхгүйгээр хэчнээн жил болж байна гэж байна.

Тэгээд бие бие рүүгээ чихдэг, салбарын яам руугаа чихдэг.

Тэгээд энэ газар чинь өөрөө энэ бүх зүйлийн суурь нь байж байдаг. Барилга байгууламжийн, бэлчээрийн, үл хөдлөх хөрөнгийн, хөгжил дэвшлийн суурь нь байж байдаг.

Тэгээд газар дээрх шийдэл маргаан Засгийн газар луу явчих юм бол орон нутагт бүх зүйл гацна. Боомилно гэсэн үг.

Биднийг жоохон байхад Ү.Аварзэд гэж хөдөлмөрийн баатар **“Энэ банкны бахинд баригдаад бид бүх зүйлийг хийж чадахгүй байна.”** гэдэг шиг одоо энэ дээшээгээ төвлөрүүлэн татах юм бол бүх зүйл орон нутагт явах боломжгүй болчихож байгаа юм.

Тийм учраас энэ асуудлаа онцгой анхаарч хандаач ээ. Онцгой анхаараач.

Ер нь Ерөнхий сайдын төвлөрлийг сааруулах энэ асуудал бол хамгийн зөв. Би хамгийн дэмждэг сэдэв. Яагаад вэ гэхээр Улаанбаатарын утаа, Улаанбаатарын түгжрэл, энэ нерв, энэ авлига, хээл хахууль бол төвлөрлийг задалснаар л бий болно.

Төвлөрөл хаана задлагдах вэ.

Аймгуудад, Дархан, Эрдэнэт, Багануур, энэ хотуудад, Төв аймаг. Эдгээр газруудад тархан байршиж байж, тэнд хүний амьдрах орчин, аймагт, сумд, Улаанбаатар хотод амьдарч байгаа хүмүүсийн амьдралын чанар ойрхон болох юм бол заавал Улаанбаатар луу орж ирж энд түгжрээд байх шаардлага байхгүй болчихно.

Барилгын материалын зах, бөөний худалдааны төв, машины захууд орон нутаг руу тархан байрших юм бол орон нутгаас хагас сайн бүтэн сайн болгон Улаанбаатар луу явья гээд байх асуудлууд байхгүй болчихно.

Энэ бүхний суурь нь орон нутагтаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээрээ, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээрээ, багт бол багийн иргэдийн Нийтийн Хурал дээрээ шийддэг энэ хуулийг цөмсөөр байгаад одоо юу ч байхгүй болгочихлоо.

Одоо орон нутагт шийддэг юм гэж байхгүй болчихсон.

Тийм учраас үүнийгээ эргэж харах ёстой гэсэн нэгдүгээр асуудлыг хэлье.

Хоёрт нь, энэ **“дабл стандарт”** гэдэг шиг тендертэй холбоотой

асуудлууд. Мэдээж тендер авсан компаниуд эрсдэлээ үүрэх нь тодорхой.

Гэхдээ 2018, 2019, 2020, 2021 онд КОВИД-ын жилүүдэд үнийн өсөлттэй компаниуд үнийн зөрүүгээ авчихсан.

Тэгтгэл сая 2023 онд шинээр хөрөнгө оруулалт тавиагүй. Тэгвэл 2020, 2021 оны зураг төсвөөр 2022 онд эхлүүлчихсэн компани 2023, 2024 онд яг дуусдагийн даваан дээр нь үхрийн сүүлэн дээрх хутга гэдэг шиг ажил нь ингээд зогсоод цаашаа ч үгүй, наашаа ч үгүй болох ийм хэмжээнд хүрчхээд байгаа юм.

Тийм учраас 2019, 2020 оны зурагтай 2021 оны төсөв дээр тавигдсан 2022 онд ажил нь эхэлсэн, 2023 онд үргэлжилсэн компаниудыг бид заавал энэ үнийн өсөлт, нөгөө ажиллах хүчний цалингийнх нь жишгийг анхаарч үзэх шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Жишээлэх юм бол Ц.Даваасүрэн сайд энэ хоёр талын гэж байна.

Тэр болохгүй зүйлүүд байгаа л байх. Тэгэхдээ яг болж байгаа, яг дуусах гэж байгаа, яг дуусдагийн даваан дээр зогсох гэж байгаа, зогсоолдоо хүрээд зогсчихсон компаниудыг авч үзэж шийдлийг нь хийхгүй бол нөгөө л дуусаагүй барилга, нөгөө л эцэс төгсгөлгүй хэрүүл маргаан, зарга дуусахгүй гэсэн ийм.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Гишүүд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж үг хэлж дууслаа. Санал хураалтыг явуулж эхэлье.

1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар

хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Нэг нэгээр нь. Санал хураалтын дүнг танилцуулъя.

14 гишүүн санал хураалтад оролцсоноос 11 гишүүн дэмжиж, 78.6 хувиар дэмжигдлээ.

2.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалтыг явуулъя. /алх цохив/

14 гишүүн санал хураалтад оролцож, 11 гишүүн дэмжиж, 78.6 хувиар дэмжигдлээ.

Энэ хуулийн төсөл дээр анхаараарай. Хэд хэдэн саналууд гишүүд хэлсэн байгаа.

3.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

71.4 хувиар дэмжигдлээ.

4.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

6.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

76.9 хувиар дэмжигдлээ.

7.Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

76.9 хувиар дэмжигдлээ.

8.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

9.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

10.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

11.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

12.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

13.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

/Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

76.9 х увиар дэмжигдлээ.

14.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

15.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Ж.Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Яах вэ, энэ дагасан хуулиудаар мэдсэн мэдээгүй аягүй олон өөрчлөлтүүд ордог оо.

Дагасан хууль орж ирж байгаад Шадар сайдтай хүртэл болчхож байсан тохиолдол бий шүү дээ.

Тэгээд бид анзаарахгүй явж байгаа зүйлүүд байдаг.

Тэгээд би түрүүнд ч бас үг хэлэхдээ хэлсэн. Энэ дагасан хуулиудаар хамгийн хохирол амсаж байгаа зүйлүүд бол орон нутаг байдаг. Дунд шатын байгууллага байдаг.

Одоо энэ Газрын тухай хуулиар 18.1.10-д энэ хуулийн 18.1.7-д заасан ерөнхий төлөвлөгөө, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар гаргасан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох шийдвэр гаргах.

Энэ бол байж болохгүй асуудал.

Энэ үндсэндээ яаж байна вэ гэхээр Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт засаг захиргаанд байгаа эрх мэдлийг татаж авч байна л гэсэн үг. Энэ бол бүх зүйлийг боомилно.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага шийдвэр гаргах ямар ч боломжгүй болно.

Өнөөдөр Газрын хууль чинь миний бодлоор 1997 онд батлагдаж байсан санагдаж байна.

1997 онд батлагдсанаас хойш аймгийн иргэдийн Хурлын онцгой бүрэн эрх бол, сумын иргэдийн Хурлын онцгой бүрэн эрх бол энэ Газрын хуультай холбоотой заалтууд байдаг.

Орон нутагт мэддэг хоёрхон л зүйл байдаг. Нэг нь орон нутгийн төсвийг хуваарилах. Дээр нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталж түүнд нийцсэн газар олголт, хяналт тавьдаг.

Энэ эрх мэдлийг орон нутгаас, аймаг, сумаас булааж авах гэж байна. Дээшээ яваад сайнаа үзэж байсан тохиолдол хэзээ ч байхгүй. Аливаа зүйл

эзнээсээ холдох бол хяналтаасаа холдоно л гэсэн үг.

Тийм учраас энэ бол ер нь огт байж болзошгүй заалт.

Ер нь үүгээр Монгол Улсын эдийн засгийг бүгдийг боомилох гэж байна. Сум болгонд баригдаж байгаа, эдийн засгийг тэлж байгаа дэлгүүр, хоршоо, одоо юу гэдэг юм газар тариалан, аймаг бүрт баригдаж байгаа хувийн хэвшлийн бүх зүйлүүд хаана босдог вэ гэхээр газар дээр босно.

Үүнийг дээш нь төвлөрүүлэн татсанаар энэ бүх эдийн засгийн тэлэлтийн үйл ажиллагаа боомилогдоно. Боомилогдоно. Үүнийг давсан авлига, хээл хахууль, албан тушаалтны дураараа авирлалт, шат дамжлагууд бүгд нэмэгдэнэ.

Тийм учраас энэ дагасан хуулиудыг дэмждэг дэмждэг гэхэд, төсвөө дэмждэг дэмждэг гэхэд энэ заалтууд арай ч байж болохгүй.

Би Ардын намын бүлгийн гишүүд энэ орон нутагт Засаг дарга нар хийж байсан, орон нутагт иргэдийн Хуралд олон удаа сууж байсан хүмүүс энэ заалтыг би дэмжихгүй байх гэж бодож байна.

Манай Д.Тогтохсүрэн дарга бол хурлын дарга, Засаг дарга маш олон удаа хийж байсан. Орон нутгийн онцгой бүрэн эрхийн асуудал шүү дээ.

Татаж янзална гээд оруулж байдаг нь хүнээр тоглож байгаа юм уу, хаашаа юм тэгээд.

Янзлах юм бол ер нь оруулахын хэрэг юу байгаа юм.

Тэгвэл тэгээд нийслэл гээд л оруулах хэрэгтэй шүү дээ. Яагаад вэ гэхээр гуя дагаж хүзүү гэдэг шиг нийслэлийг янзална гээд орон нутгийн бүх эрх мэдлийг татаж авч болохгүй.

Тийм болохоор энэ бол одоо ямар ч дэмжих боломжгүй санал байна.

Ер нь Барилга, хот байгуулалтын яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар энэ саналаа татаж авах хэрэгтэй л гэж би ингэж үзэж байгаа юм.

Тэр нийслэлийг нь мэдэхгүй. Нийслэл гээд тэр оруулах нь тусдаа асуудал байх.

Г.Тэмүүлэн: Ж.Батсуурь гишүүнд баярлалаа. Санал хураалтыг явуулъя.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

76.9 хувиар дэмжигдлээ.

16.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

76.9 хувиар дэмжигдлээ.

17.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар

хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

69.2 хувиар дэмжигдлээ.

18.Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

19.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

76.9 хувиар дэмжигдлээ.

20.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалтын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

21.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

22.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

76.9 хувиар дэмжигдлээ.

23.“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

24.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

25.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

26.“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай

холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

27.“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

28.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар

хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

84.6 хувиар дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хууль, Улсын Их Хурлын 7 тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулъя.

Хуралдаанд оролцсон ажлын хэсэг болоод Байнгын хорооны гишүүдэд баярлалаа.

Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 21 минут үргэлжилж, 11 цаг 52 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД